



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 05 өдөр

Дугаар А/395

Булган сум

Үндэсний их сурын улсын
аварга шалгаруулах тэмцээнд оролцох баг,
тамирчдад дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Биеийн тамир, спортын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.9 дэх заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Соёлын биет бус өвийг сурталчлан таниулах, өвлөн уламжлуулах зорилгоор Улаанбаатар хотод 2025 оны 06 дугаар сарын 06-08-ны өдрүүдэд зохион байгуулагдах Үндэсний их сурын улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох баг, тамирчдын байр, хоолны зардалд 2,000,000 (хоёр сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Аймгийн Засаг даргын нөөцийн хөрөнгөөс санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Наранбаяр)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР